



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

ХҮРЭЭМАРАЛ СУМЫН ЦЭЦЭРЛЭГИЙН 2020 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН,  
ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

АУДИТЫН КОД: БНА-2021/135/СТА-ТШЗ

Баянхонгор 2021 он	Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын дарга бөгөөд Тэргүүлэх аудитор: Б.Мөнхбат Утас: 99007576      Цахим хаяг: munkhbatb@audit.gov.mn Хэлтсийн дарга бөгөөд аудитын менежер: А.Цээням Утас: 88011833      Цахим хаяг: tseenyama@audit.gov.mn “Баянташаагийн эх аудит” ХХК-ийн аудитор: Ч.Чимгээ Утас: 89915909      Цахим хаяг: bte.audit@yahoo.com Цахим хуудас: <a href="http://www.audit.mn">www.audit.mn</a>
-----------------------	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



**Товчилсон үгийн жагсаалт**

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт

## Агуулга

1.Төрийн аудитын санал, дүгнэлт /Эх хувь/.....	3
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан .....	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан .....	5
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан .....	6
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан .....	7
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан .....	9
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан .....	9
2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан .....	11
3.Аудитын тайлан .....	11
3.1. Ерөнхий зүйл .....	11
3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй .....	12
3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт .....	12
3.4. Материаллаг байдал .....	13
3.5. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд .....	13
3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт .....	14
3.7. Шилэн дансны мэдээлэл.....	15
3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт .....	16
3.9. Аудитын илрүүлэлт .....	16
Залруулсан алдаа.....	16
Аудитын зөвлөмж .....	16
3.10. Балансын дараах үйл явдал болон дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц бусад чухал асуудлууд .....	16
4. Менежментийн захидал.....	16
5. Хавсралт Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт .....	18



**БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

64101 Баянхонгор аймаг,  
Баянхонгор сум, Номгон баг  
Утас, факс 7044 2584

E-mail: bayankhongor@audit.gov.mn

Г БАЯНХОНГОР АЙМГИЙН  
ХҮРЭЭМАРАЛ СУМЫН ЦЭЦЭРЛЭГИЙН  
ЭРХЛЭГЧ Я.ОЮУНЧИМЭГ ТАНАА 7

2021.02.18 № 2/45

танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

Г **Аудитын гэрчилгээ** 7

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Баянхонгор аймгийн Хүрээмарал сумын Цэцэрлэгийн 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

**Зөрчилгүй санал дүгнэлт**

Баянхонгор аймгийн Хүрээмарал сумын Цэцэрлэгийн 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдлын тайлан, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

**Санал дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Баянхонгор аймгийн Хүрээмарал сумын Цэцэрлэгийн 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, программ хангамж, дотоод хяналтын систем болон

2021 А4 ТООТ

005020960

удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

### **Үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудитыг хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

ДАРГА БӨГӨӨД ТЭРГҮҮЛЭХ  
АУДИТОР Б.МӨНХБАТ



**2.Аудит хийсэн санхүүгийн тайлан**  
**2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан**

/Төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>31,450,078.00</u></b>	<b><u>51,282,228.00</u></b>
<b>33</b>	<b>АВЛАГА</b>	00.00	10,620,000.00
<b>335</b>	<b>Бусад авлага</b>	00.00	10,620,000.00
3351	Байгууллагаас авах авлага	00.00	10,620,000.00
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	31,450,078.00	40,662,228.00
<b>354</b>	<b>Хангамжийн материал</b>	31,450,078.00	40,662,228.00
35410	Бичиг хэргийн материал	50,000.00	50,000.00
35420	Аж ахуйн материал	00.00	1,219,150.00
35470	Бусад хангамжийн материал	31,400,078.00	39,393,078.00
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>369,023,031.90</u></b>	<b><u>365,274,931.30</u></b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	369,023,031.90	365,274,931.30
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>	359,047,031.90	355,298,931.30
39201	Барилга, байгууламж, орон сууц	342,444,131.00	342,444,131.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	-7,952,769.88	-13,727,373.76
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	40,086,242.00	45,874,742.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	-28,403,603.90	-31,850,784.62
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	31,388,366.37	34,588,366.37
39208	Хуримтлагдсан элэгдэл	-21,454,179.27	-24,968,995.27
39217	Ном	2,938,845.58	2,938,845.58
<b>393</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	9,976,000.00	9,976,000.00
39301	Програм хангамж	400,000.00	200,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-400,000.00	-200,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	9,976,000.00	9,976,000.00
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b><u>400,473,109.90</u></b>	<b><u>416,557,159.30</u></b>
<b>4</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	<b><u>150,012.00</u></b>	<b><u>194,349.00</u></b>
<b>41</b>	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	150,012.00	194,349.00
<b>413</b>	<b>Өглөг</b>	150,012.00	194,349.00
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	00.00	194,349.00
<b>4136</b>	<b>Бусад өглөг</b>	150,012.00	00.00
41361	Байгууллагад төлөх өглөг	150,012.00	00.00
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b><u>400,323,097.90</u></b>	<b><u>416,362,810.30</u></b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	400,323,097.90	416,362,810.30
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	102,844,487.00	102,844,487.00
51101	Өмч: - төрийн	102,844,487.00	102,844,487.00
<b>512</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	14,849,323.86	30,889,036.26
51210	Өмнөх үеийн үр дүн	14,849,323.86	14,849,323.86
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	16,039,712.40
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	282,629,287.04	282,629,287.04
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b><u>400,473,109.90</u></b>	<b><u>416,557,159.30</u></b>

**2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан**

/Төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>230,809,738.00</b>	<b>285,219,170.00</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>3,928,700.00</b>	<b>7,448,500.00</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	3,928,700.00	7,448,500.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	3,928,700.00	7,448,500.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	3,928,700.00	7,448,500.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>226,881,038.00</b>	<b>277,770,670.00</b>
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	206,238,600.00	228,833,700.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	00.00	25,535,070.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	00.00	25,535,070.00
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	20,616,800.00	23,401,900.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	20,616,800.00	23,401,900.00
<b>1340</b>	<b>Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих</b>	25,638.00	00.00
134001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	25,638.00	00.00
<b>2</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>241,935,028.92</b>	<b>269,179,457.60</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>241,935,028.92</b>	<b>269,179,457.60</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	237,279,795.92	239,236,013.29
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	150,026,798.00	162,357,240.69
210101	Үндсэн цалин	150,026,798.00	151,264,340.69
210102	Нэмэгдэл	00.00	4,944,000.00
210104	Урамшуулал	00.00	6,148,900.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	19,044,052.00	20,368,729.00
210201	Тэтгэврийн даатгал	13,159,743.00	13,960,754.00
210202	Тэтгэмжийн даатгал	1,481,618.00	1,623,940.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,205,766.00	1,299,153.00
210204	Ажилгүйдлийн даатгал	290,630.00	310,964.00
210205	Эрүүл мэндийн даатгал	2,906,295.00	3,173,918.00
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	15,154,863.00	21,823,300.00
210301	Гэрэл, цахилгаан	2,881,563.00	1,241,200.00
210302	Түлш, халаалт	12,273,300.00	20,582,100.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	3,485,489.00	3,388,873.00
210401	Бичиг хэрэг	146,000.00	337,000.00
210402	Тээвэр, шатахуун	1,616,940.00	1,376,700.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,134,266.00	942,673.00
210404	Ном, хэвлэл	00.00	30,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	00.00	242,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	588,283.00	460,500.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	27,885,553.00	15,876,170.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	42,053.00	312,450.00
210502	Хоол, хүнс	27,439,500.00	15,325,220.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	404,000.00	238,500.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	6,338,612.00	1,173,500.00

**Хүрээмэрал цэцэрлэгийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит**

210601	Багаж, техник, хэрэгсэл	00.00	1,173,500.00
210604	Урсгал засвар	6,338,612.00	00.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>84,000.00</b>	<b>00.00</b>
210702	Дотоод албан томилолт	84,000.00	00.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>204,900.00</b>	<b>356,600.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	204,900.00	106,600.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	00.00	250,000.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>15,055,528.92</b>	<b>13,891,600.60</b>
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	505,350.00	1,155,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	14,550,178.92	12,736,600.60
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>4,655,233.00</b>	<b>29,943,444.31</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>115,638.00</b>	<b>25,535,070.00</b>
213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж	25,638.00	00.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	00.00	17,661,070.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	00.00	7,874,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	90,000.00	00.00
<b>2134</b>	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	<b>457,937.00</b>	<b>1,578,600.00</b>
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	457,937.00	1,578,600.00
<b>2135</b>	<b>Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>4,081,658.00</b>	<b>2,829,774.31</b>
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	4,081,658.00	2,829,774.31
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b>-11,125,290.92</b>	<b>16,039,712.40</b>
<b>5</b>	<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	<b>-11,125,290.92</b>	<b>16,039,712.40</b>

**2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан**

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>		
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b>226,881,038.00</b>	<b>277,770,670.00</b>
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>226,881,038.00</b>	<b>277,770,670.00</b>
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	206,238,600.00	228,833,700.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>00.00</b>	<b>25,535,070.00</b>
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	00.00	25,535,070.00
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	<b>20,616,800.00</b>	<b>23,401,900.00</b>
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	20,616,800.00	23,401,900.00
<b>1340</b>	<b>Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих</b>	<b>25,638.00</b>	<b>00.00</b>
134001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	25,638.00	00.00
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b>226,881,038.00</b>	<b>276,230,670.00</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>226,881,038.00</b>	<b>276,230,670.00</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>222,225,805.00</b>	<b>246,287,225.69</b>

Хүрээмарал цэцэрлэгийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	148,804,199.00	162,230,384.69
210101	Үндсэн цалин	114,429,399.00	116,427,321.27
210102	Нэмэгдэл	12,917,300.00	20,599,699.42
210104	Урамшуулал	11,058,800.00	24,595,600.00
210105	Гэрээт ажлын хөлс	10,398,700.00	607,764.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	20,266,651.00	20,301,236.00
210201	Тэтгэврийн даатгал	14,157,709.00	13,895,657.00
210202	Тэтгэмжийн даатгал	1,492,775.00	1,715,401.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,192,167.00	1,237,527.00
210204	Ажилгүйдлийн даатгал	311,100.00	313,823.00
210205	Эрүүл мэндийн даатгал	3,112,900.00	3,138,828.00
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	17,158,863.00	21,823,300.00
210301	Гэрэл, цахилгаан	2,881,563.00	1,241,200.00
210302	Түлш, халаалт	14,277,300.00	20,582,100.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	3,209,039.00	3,426,985.00
210401	Бичиг хэрэг	146,000.00	29,000.00
210402	Тээвэр, шатахуун	1,056,940.00	1,376,700.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,317,116.00	942,673.00
210404	Ном, хэвлэл	42,200.00	30,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	58,500.00	242,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	588,283.00	806,612.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	27,885,553.00	28,299,220.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	42,053.00	1,531,600.00
210502	Хоол, хүнс	27,439,500.00	15,325,220.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	404,000.00	11,442,400.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	3,788,600.00	4,353,500.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	00.00	4,353,500.00
210604	Урсгал засвар	3,788,600.00	00.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	84,000.00	00.00
210702	Дотоод албан томилолт	84,000.00	00.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	204,900.00	356,600.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	204,900.00	106,600.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	00.00	250,000.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	824,000.00	5,496,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	824,000.00	5,496,000.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>4,655,233.00</b>	<b>29,943,444.31</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	115,638.00	25,535,070.00
213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж	25,638.00	00.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	00.00	17,661,070.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	00.00	7,874,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	90,000.00	00.00
<b>2134</b>	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	457,937.00	1,578,600.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	457,937.00	1,578,600.00
<b>2135</b>	<b>Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	4,081,658.00	2,829,774.31

Хүрээмэрал цэцэрлэгийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	4,081,658.00	2,829,774.31
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	00.00	1,540,000.00
	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	00.00	00.00
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	00.00	1,540,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	00.00	1,540,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	00.00	1,540,000.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	00.00	1,540,000.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	00.00	-1,540,000.00
	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	00.00	00.00
7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	00.00	00.00
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	00.00	00.00
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	00.00	00.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	00.00	00.00

**2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан / төгрөгөөр /**

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	92,416,831.00	155,322,218.50	35,997,741.84	00.00	211,741,307.66
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	92,416,831.00	155,322,218.50	35,997,741.84	00.00	211,741,307.66
C07	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	11,923,490.16	00.00	-11,923,490.16
C08	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	102,844,487.00	282,629,287.04	14,849,323.86	00.00	400,323,097.90
D01	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	102,844,487.00	282,629,287.04	14,849,323.86	00.00	400,323,097.90
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	102,844,487.00	282,629,287.04	14,849,323.86	00.00	400,323,097.90
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	16,039,712.40	00.00	16,039,712.40
D09	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	102,844,487.00	282,629,287.04	30,889,036.26	00.00	416,362,810.30

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны		Зөрүү	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	дүн	хувь
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл				
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	252,235,600.00	247,827,225.69	-4,408,374.31	98.25
21	УРСГАЛ ЗАРДАЛ	252,235,600.00	247,827,225.69	-4,408,374.31	98.25
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	252,151,100.00	247,827,225.69	-4,323,874.31	98.29
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	163,282,500.00	162,230,384.69	-1,052,115.31	99.36
210101	Үндсэн цалин	116,968,500.00	116,427,321.27	-541,178.73	99.54
210102	Нэмэгдэл	20,599,700.00	20,599,699.42	-0.58	100.00
210104	Урамшуулал	24,595,600.00	24,595,600.00	0.00	100.00
210105	Гэрээт ажлын хөлс	1,118,700.00	607,764.00	-510,936.00	54.33
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	20,520,400.00	20,301,236.00	-219,164.00	98.93
210201	Тэтгэврийн даатгал	13,953,800.00	13,895,657.00	-58,143.00	99.58
210202	Тэтгэмжийн даатгал	1,641,700.00	1,715,401.00	73,701.00	104.49
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,313,400.00	1,237,527.00	-75,873.00	94.22
210204	Ажилгүйдлийн даатгал	328,300.00	313,823.00	-14,477.00	95.59
210205	Эрүүл мэндийн даатгал	3,283,200.00	3,138,828.00	-144,372.00	95.60
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	22,401,900.00	21,823,300.00	-578,600.00	97.42
210301	Гэрэл, цахилгаан	2,371,200.00	1,241,200.00	-1,130,000.00	52.34
210302	Түлш, халаалт	19,730,700.00	20,582,100.00	851,400.00	104.32
210303	Цэвэр, бохир ус	300,000.00	0	-300,000.00	0.00
2104	Хангамж, бараа матер иалын зардал	3,792,800.00	3,426,985.00	-365,815.00	90.36
210401	Бичиг хэрэг	76,100.00	29,000.00	-47,100.00	38.11
210402	Тээвэр, шатахуун	1,200,000.00	1,376,700.00	176,700.00	114.73
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,368,800.00	942,673.00	-426,127.00	68.87
210404	Ном, хэвлэл	42,300.00	30,000.00	-12,300.00	70.92
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	242,000.00	242,000.00	0.00	100.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	863,600.00	806,612.00	-56,988.00	93.40
2105	Нормативт зардал	28,403,800.00	28,299,220.00	-104,580.00	99.63
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	1,539,500.00	1,531,600.00	-7,900.00	99.49
210502	Хоол, хүнс	15,325,300.00	15,325,220.00	-80.00	100.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	11,539,000.00	11,442,400.00	-96,600.00	99.16
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	5,825,600.00	4,713,500.00	-1,112,100.00	80.91
210601	Багаж, техник, хэрэгсэл	4,796,000.00	4,713,500.00	-82,500.00	98.28
210604	Урсгал засвар	1,029,600.00	0	-1,029,600.00	0.00
2107	Томилот, зочны зардал	78,900.00	0	-78,900.00	0.00
210702	Дотоод албан томилолт	78,900.00	0	-78,900.00	0.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,051,600.00	356,600.00	-695,000.00	33.91
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	801,600.00	106,600.00	-695,000.00	13.30
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	250,000.00	250,000.00	0.00	100.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	6793600	6676000	-117,600.00	98.27
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	6,793,600.00	6,676,000.00	-117,600.00	98.27

**Хүрээмарал цэцэрлэгийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит**

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны		зөрүү	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	дүн	хувь
213	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	104600.00	104000.00	-600.00	99.43
2132	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	104,600.00	104,000.00	-600.00	99.43
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	104,600.00	104,000.00	-600.00	99.43
	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	275,282,100.00	267,536,678.00	-7,745,422.00	97.19
1310	<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	251,670,600.00	248,070,802.00	-3,599,798.00	98.57
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	251,670,600.00	248,070,802.00	-3,599,798.00	98.57
1320	<b>ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	23,611,500.00	19,465,876.00	-4,145,624.00	82.44
132001	Орон нутгийн төсвөөс	23,611,500.00	19,465,876.00	-4,145,624.00	82.44
61	<b>БАЙГУУЛЛАГЫН ТОО</b>	01.00	01.00	0.00	100.00
610001	Төсвийн байгууллага	01.00	01.00	0.00	100.00
62	<b>АЖИЛЛАГСАДЫН ТОО</b>	20.00	20.00	0.00	100.00
620001	Удирдах ажилтан	01.00	01.00	0.00	100.00
620002	Гүйцэтгэх ажилтан	10.00	10.00	0.00	100.00
620003	Үйлчлэх ажилтан	07.00	07.00	0.00	100.00
63	<b>СУРАЛЦАГЧДЫН ТОО (ЖИЛИЙН ДУНДЖААР)</b>	188.00	188.00	0.00	100.00
631	<b>СУРГУУЛИЙН ӨМНӨХ БОЛОВСРОЛЫН БАЙГУУЛЛАГА</b>	01.00	01.00	0.00	100.00
631001	Төрийн өмчит СӨБ байгууллага	01.00	01.00	0.00	100.00
65	<b>ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ</b>	20.00	20.00	0.00	100.00
650004	СЭБ болон бага, дунд боловсролын албан хаагч (ТҮБД)	12.00	12.00	0.00	100.00
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	08.00	08.00	0.00	100.00

**2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан / төгрөгөөр /**

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Гүйцэтгэл
	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>		
<b>I</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>		<b>25,535,070.00</b>
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	0.00	25,535,070.00
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>		25,535,070.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж		17,661,070.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг		7,874,000.00
<b>II</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	0.00	25,535,070.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>		25,535,070.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		25,535,070.00

**3.Аудитын тайлан**

**3.1. Ерөнхий зүйл**

Төрийн аудитын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасан бүрэн эрхийн хүрээнд Хүрээмарал сумын цэцэрлэгийн 2020 оны

санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүгнэлтийг эрхлэгч Я.Оюунчимэг танд танилцуулж байна.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтад хийсэн үнэлгээ, аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал бүхий аудитын дүгнэлт түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан толилуулав.

Аудитын тайланд шалгагдагч этгээдэд төсвийн хөрөнгийн бүрдүүлэлт, зарцуулалтад тавих хяналтыг сайжруулах, үр ашигтай зарцуулах талаар өгсөн зөвлөмжүүдийг менежментийн захидалд тусгасан болно.

Аудитыг 2021 оны 01 дүгээр сарын 24-ээс 2021 оны 02 дугаар сарын 18-ны хооронд “Баянташаагийн эх Аудит” ХХК-нийн аудитор Ч.Чимгээ хариуцаж хэрэгжүүлэв.

Тус цэцэрлэг нь 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийх хүсэлтийг Төрийн Аудитын газарт мөн оны 10 дугаар сарын 29-ны өдрийн 11 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

### **3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй**

Хүрээмарал сумын цэцэрлэгийн үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Хүүхдийн сурах үйлийг дэмжиж, сурлагын хоцрогдолгүй сургахад бүх талын оролцоо, хамтын ажиллагааг өргөжүүлж, тэдний хөгжил төлөвшил, сурлагын амжилт, чанарт ахиц гаргах, багш мэргэжлээрээ тасралтгүй хөгжих боломжийг бүрдүүлэх;

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд өөрчлөлт гараагүй байна. Дараах хууль тогтоомжийг мөрдөж байна.

- Төрийн аудитын тухай хууль
- Төсвийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Шилэн дансны тухай хууль
- Монгол Улсын 2020 оны Төсвийн тухай хууль
- Татварын багц хуулиуд
- Нийгмийн даатгалын тухай хууль
- Сургуулийн өмнөх боловсролын тухай хууль
- Хүүхдийн эрхийн тухай хууль
- Хүүхэд хамгааллын тухай хууль
- Хүүхэд хамгааллын талаарх бусад үндэсний бодлого, дүрэм, журам

### **3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт**

Хүрээмарал сумын цэцэрлэгийн санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв бэлтгэх үүрэгтэй.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Хүрээмарал сумын Цэцэрлэгийн санхүүгийн үйл ажиллагаанд аймгийн Санхүүгийн хяналт, дотоод аудитын алба дотоод хяналт хийгээгүй, Төрийн аудитын газар 2020 оны санхүүгийн баримтад завсрын хяналт хийсэн байна. Хяналтаар 2744,0 мянган төгрөгийн зөрчил илэрч албан шаардлага хүргүүлсний дагуу 2200,0 мянган төгрөгийн гулгуур, 544,0 мянган төгрөгийн элсний хайрцаг, хогийн савыг Сод арвай ХКомпаниас хүлээн авч хөрөнгөнд бүртгэж, зөрчлийг арилгаж ажилласан байна. Хэрэгжилтийн биелэлтийг 2020 оны №25; № 33 тоотор тус тус хүргүүлжээ.

Тус байгууллагын дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд “Дунд” гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн үе шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй гэж үзлээ.

### 3.4. МАТЕРИАЛЛАГ БАЙДАЛ

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн тайлангийн нийт зардлыг сонгож, эрсдэлийн түвшнийг “Дунд” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлын түвшнийг 2019 оны жилийн эцсийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 241909.3 мянган төгрөгөөс 2 хувиар буюу 4838.2 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тооцсоныг гүйцэтгэлийн үе шатанд 2020 оны жилийн эцсийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 269179.5 мянган төгрөгөөс 2 хувиар буюу 5383.6 мянган төгрөгөөр тооцов.

Гүйцэтгэлийн шатанд тусгай зориулалттай бараа материал дансанд 3740,0 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө бүртгэгдсэн байсныг санхүүгийн тайланд залруулсныг материаллаг бус алдаанд тооцов.

### 3.5. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Хүрээмарал сумын цэцэрлэгийн 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн үзүүлэлтийг өмнөх онтой харьцуулахад өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан авлага, бараа материал, үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт /төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	31,450.1	51,282.2	19,832.2
Мөнгөн хөрөнгө	-	-	-
Авлага	-	10,620.0	10,620.0
Урьдчилгаа	-	-	-
Бараа материал	31,450.1	40,662.2	9,212.2
<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	369,023.0	365,274.9	(3,748.1)
Үндсэн хөрөнгө	427,233.6	436,022.1	8,788.5
Хуримтлагдсан элэгдэл	(58,210.6)	(70,747.2)	(12,536.6)
<b>Нийт хөрөнгө</b>	400,473.1	416,557.2	16,084.0
Өр төлбөр	150.0	194.3	44.3
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	400,323.1	416,362.8	16,039.7
<b>Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн</b>	400,473.1	416,557.2	16,084.0

Эх сурвалж: Тус байгууллагын 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан

Үндсэн хөрөнгийн 436022,1 мянган төгрөг болж өмнөх оноос 8788,5 мянган төгрөг нэмэгдсэн нь төсвийн хөрөнгөөр 1540,0 мянган төгрөгийн хөрөнгө худалдан авч, БШСУЯамнаас хандиваар 5248,5 мянган төгрөгийн зөөврийн компьютер хандивласантай холбоотой байна.

Тайлант онд эргэлтийн хөрөнгө 19832,2 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь авлага 10620,0 мянган, бараа материалын үлдэгдэл 9212,2 мянган төгрөгөөр тус тус нэмэгдсэнтэй холбоотой байна.

Авлагын үлдэгдэл нэмэгдсэн нь гал тогооны дагалдах хэрэгслийн үнэ 1520.0 мянган төгрөгийг Тулга техник ХХК-д, зөөлөн эдлэлийн үнэ 9100,0 мянган төгрөгийг М.Цэцэгт гэрээний дагуу тус тус шилжүүлснээс шалтгаалсан байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 40662,2 мянган төгрөг болж 9212,2 мянган төгрөгөөр өссөн нь тайланд онд аж ахуйн материал, бусад хангамжийн бараа материал өссөнөөс шалтгаалжээ.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 416362,8 мянган төгрөг болж 16039,7 мянган төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүн өссөнөөс шалтгаалжээ.

Тус байгууллагын санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого 285219,2 мянган төгрөг болж, өмнөх оноос 54409,5 мянган төгрөгөөр буюу 19,1 хувиар өссөн байна.

Төсөв байгууллагын өөрийн орлого өмнөх оноос 3519,8 мянган төгрөгөөр өссөнтэй нь үнэ төлбөргүй хүлээж авсан орлого өссөнтэй, тусламж санхүүжилтийн орлого нэмэгдсэн нь тусгай зориулалтын шилжүүлгийн санхүүжилт 22595,1 мянган, нэмэлт санхүүжилт 25535,1 мянган, орон нутгийн төсвөөс олгосон санхүүжилт 2785,1 мянган төгрөгөөр тус тус нэмэгдсэнтэй холбоотой байна.

Нийт зардал 269179,5 мянган төгрөг болж нь өмнөх оноос 27244,4 мянган төгрөгөөр буюу 1,2 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан зардлууд нь цалин, хөлс болон нэмэгдэл урамшлын зардал 12330,4 мянган, нийгмийн даатгалын шимтгэлийн зардал 1324,6 мянган, байр ашиглалттай холбоотой тогтмол зардал 6668,4 мянган төгрөгөөр тус тус нэмэгдэж, норматив зардал 12009,5 мянган, бараа үйлчилгээний бусад зардал 1163,9 мянган төгрөгөөр тус тус буурсантай холбоотой байна.

### **3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт**

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### **Төсвийн төлөвлөлт**

Тус байгууллагын 2020 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 241532,0 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 241532,0 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 10703,6 мянган төгрөгөөр нэмэгдүүлж, 252235,6 мянган төгрөгөөр баталсан байна.

#### **Төсвийн гүйцэтгэл**

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 5 арга хэмжээг санхүүжүүлэхээр 252235,6 мянган төгрөгийн төсөв баталснаас 228833,7 мянган төгрөгийг тусгай зориулалтын шилжүүлгийн санхүүжилтээр, 23401,9 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Төсвийн гүйцэтгэлээр тусгай зориулалтын шилжүүлгийн санхүүжилтээс 226004,0 мянган, орон нутгийн төсвөөс 21823,2 мянган төгрөгийн санхүүжилт авч, нийт 247827,3 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, урсгал үйл ажиллагааны зардалд зарцуулсан байна.

Батлагдсан төсвөөс 4408,3 мянган төгрөг дутуу зарцуулсан нь цалингийн болон нийгмийн даатгалын зардлыг 1271,3 мянган, байр ашиглалттай холбоотой тогтмол зардлыг 578,6 мянган, хангамж бараа материалын зардлыг 365,8 мянган, нормативт зардлыг 104,6 мянган, эд хогшил, урсгал засварын зардлыг 1112,1 мянган төгрөгөөр тус тус хэмнэсэнтэй холбоотой байна.

Нийт төсөвт зардлыг 4408,4 мянган төгрөгөөр дутуу зарцуулсан нь сургуулийн өмнөх боловсрол хөтөлбөрийн боловсролын стандарт, сургалтын үйл ажиллагааны зардал 3599,1 мянган, явуулын багшийн үйлчилгээний зардал 613,2 мянган, байр ашиглалтын үйлчилгээний зардал 1578,6 мянган, цэцэрлэгийн хүүхдийн хоолын зардал 0,1 мянган, сургалтын хэвийн үйл ажиллагааны зардал 119,8 мянган төгрөгөөр тус тус хэмнэгдсэнтэй холбоотой байна.

**Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний зардлын гүйцэтгэл /мянган төгрөг/**

Д/Д	Хөтөлбөр, арга хэмжээний		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
	Код	Нэр				
1	71801	Сургуулийн өмнөх боловсрол хөтөлбөр	252235,6	247827,2	(4408,4)	98,2
1.1	81834	Боловсролын стандарт, сургалтын үйл ажиллагааны зардал	177371,6	175275	(2096,6)	98,9
1.2	81833	Явуулын багшийн үйлчилгээ	5203,7	4590,5	(613,2)	88,2
1.3	81835	Сургалтын хэвийн үйл ажиллагааны зардал	30933,1	30813,3	(119,8)	99,6
1.4	80109	Байр ашиглалтын үйлчилгээ	23401,9	21823,3	(1578,6)	93,2
1.5	81807	Цэцэрлэгийн хүүхдийн хоол	15325,3	15325,2	(0.1)	100

Эх сурвалж: Тус байгууллагын 2020 оны төсвийн хэлбэлзлийн тайлан

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 2.5-д харуулав.

**Нэмэлт санхүүжилт**

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Аймгийн Боловсрол, соёл урлагийн газраас ажиллагсдын 5 жилийн тэтгэмжийн санхүүжилт 7874,0 мянган, тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж 17661,1 мянган төгрөгийн нийт 25535,1 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлж зориулалтын дагуу тэтгэмжийг олгосон.

**3.7. Шилэн дансны мэдээлэл**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны хуулийн дагуу 27 төрлийн 151 мэдээлэл байршуулахаас батлагдсан төсөв, гүйцэтгэл, хэтрэлт хэмнэлтийн шалтгаан /тайлбарын хамт /, тухайн жилийн төсөвт орсон нэмэлт, өөрчлөлт, цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн

бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээ, санхүүгийн тайлан, хөрөнгийн болон урсгал зардалд тусгагдсан арга хэмжээний тендерийн ерөнхий мэдээлэл, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр, аудитын тайлан, дүгнэлт, зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тайлан, тухайн байгууллагын хууль тогтоомжийн дагуу төвлөрүүлэх төлбөр, хураамж, зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээнд орсон өөрчлөлт, худалдан авах ажиллагаанд хийсэн аудитын тайлан, дүгнэлт болон бусад хяналт шалгалтын дүн зэрэг нийт 23 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан, 2 мэдээллийг байршуулах хугацаа болоогүй байна.

Хүснэгт 3. www.shilendans.gov.mn цахим хуудсан дахь мэдээлэл

Д/д	Хугацаа	Төрөл	Удаа	Хугацаанд нь оруулсан	Хугацаа хоцроосон	Хугацаа болоогүй
1	Бүтэн жил	11	11	8	1	2
2	Хагас жил	4	4	3	1	
3	Улирал бүр	1	4	4		
4	Сар бүр	3	36	35	1	
5	Тухай бүр	8	96	76	20	
	Нийт	27	151	126	23	2

Эх сурвалж: www.shilendans.gov.mn цахим хуудас

### 3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар зөрчилгүй шалгагдаж, зөвлөмж, албан шаардлага аваагүй байна.

### 3.9. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 5454,3 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 3934,3 мянган төгрөгийн алдааг залруулж, 1520,0 мянган төгрөгийн алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх талаар 2 зөвлөмж өглөө.

#### Залруулсан алдаа

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын алдаатай дараах залруулгыг санхүүгийн тайланд тусгаж, баталгаажуулав. Үүнд:

1. Тусгай зориулалттай бараа материал дансанд 5 нэр төрлийн 3740,0 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийн шинж чанар бүхий хөрөнгийг бүртгэсэн байна.  
**Шийдвэрлэсэн нь:** Санхүүгийн тайланд 3740,0 мянган төгрөгийн тусгай зориулалтын эргэлтийн хөрөнгийг үндсэн хөрөнгийн дансанд бүртгэж тайлант үеийн үр дүнд залруулга хийв.
2. Цалин, НДШ-ийн тооцооллыг анхан шатны баримтаар түүвэрлэн нягтлан бодох бүртгэлийн журналуудтай тулган баталгаажуулж түүвэрлэн шалгахад нийт түүврээр 182725,9 мянган төгрөгийн зардал гарсан байхад санхүүгийн тайланд 194,3 мянган төгрөгөөр дутуу бүртгэж, ХХОАТ-ын өглөгийг санхүүгийн тайланд тусгаагүй тохируулах бичилтээр хааж бичсэн.  
**Шийдвэрлэсэн нь:** Санхүүгийн тайланг 194,3 мянган төгрөгөөр залруулж, ХХОАТатварын өглөгийг бүртгэж, тайлант үеийн үр дүнд залруулга хийв.

#### Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил

Санхүүгийн тайлангийн аудитаар акт, албан шаардлага өгөгдөөгүй болно.

#### Аудитын зөвлөмж

Аудитаар илэрсэн 1520,0 мянган төгрөгийн алдаа, зөрчилд 2 зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгав.

### 3.10. Балансын дараах үйл явдал болон дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц бусад чухал асуудлууд

Дараагийн аудитаар авч үзэх асуудал илэрсэнгүй.

#### 4. Менежментийн захидал

Менежментийн захидалд цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

##### 1. Балансын данстай холбоотой асуудал

**1.1 Илрүүлэлт:** Гал тогооны дагалдах хэрэгслийн үнэ 1520.0 мянган төгрөгийг Тулга техник ХХК-д 2020 оны 12 сарын 30-нд шилжүүлж авлага үүссэн. Уг авлагыг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.4."хүчин төгөлдөр бус анхан шатны баримтаар, эсхүл анхан шатны баримтаар баталгаажуагүй ажил, гүйлгээг бүртгэхгүй байх" заалтыг зөрчсөн.

**1.2. Эрсдэл:** Үргүй зардал гарч, өр авлага нэмэгдэх

**1.3 Өгсөн зөвлөмж:** Тулга техник ХХК-аас гал тогооны дагалдах хэрэгслийг хүлээн авч авлагыг бүрэн барагдуулах, Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1."төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах гэсэн заалтыг хэрэгжүүлэн өр авлага үүсгэхгүй ажиллах.

**1.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:** Зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана.

##### 2. Зардлын данстай холбоотой асуудал

**2.1. Илрүүлэлт:** Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг шалгахад 27 төрлийн 151 мэдээлэл байршуулахаас батлагдсан төсөв, гүйцэтгэл, хэтрэлт хэмнэлтийн шалтгаан /,тайлбарын хамт /,тухайн жилийн төсөвт орсон нэмэлт, өөрчлөлт, цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээ, санхүүгийн тайлан, хөрөнгийн болон урсгал зардалд тусгагдсан арга хэмжээний тендерийн ерөнхий мэдээлэл, таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа зэрэг нийт 23 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан байна.

**2.2. Эрсдэл:** Мэдээллийн ил тод байдал алдагдах

**2.3. Өгсөн зөвлөмж:** Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасан "энэ хуулийн 3.1.1., 3.1.2-т заасан байгууллага, албан тушаалтан дараах мэдээллийг тогтмол мэдээлнэ" заалтыг мөрдөж ажиллах.

**2.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:** Зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2021 оны 05 дугаар сарын 15-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан тухайн байгууллагын удирдлагуудад талархал илэрхийлье.

#### АУДИТЫН ТАЙЛАНГ:

Бэлтгэсэн:  
АУДИТОР

Ч.Чимгээ  
Огноо: 2021.02.18

Анхан шатанд хянасан:  
ХЭЛТСИЙН ДАРГА БӨГӨӨД АУДИТЫН  
МЕНЕЖЕР

А.ЦЭЭНЯМ  
Огноо: 2021.02.18

Хоёр дахь шатанд хянасан:  
ДАРГА БӨГӨӨД ТЭРГҮҮЛЭХ  
АУДИТОР

Б.МӨНХБАТ  
Огноо: 2021.02.18

**5. Хавсралт Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт**

Огноо	Аудитын нэр:	Хүрээмэрал сумын цэцэрлэгийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит	Аудитын код:		
2021			БНА-2021/135/СТА-ТШЗ		
Шалгагдсан байгууллагын нэр:		Хүрээмэрал сумын цэцэрлэг		Мянган төгрөг	
№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
				Албан тушаал	Овог нэр
	1	2	3	4	5
1	Цалин, НДШ-ийн тооцооллыг анхан шатны баримтаар түүвэрлэн нягтлан бодох бүртгэлийн журналуудтай тулган баталгаажуулж түүвэрлэн шалгахад нийт түүврээр 182725,9 мянган төгрөгийн зардал гарсан байхад санхүүгийн тайланд 194,3 мянган төгрөгөөр дутуу бүртгэж, ХХОАТ-ын өглөгийг санхүүгийн тайланд тусгаагүй тохируулах бичилтээр хааж бичсэн.	194,3	Санхүүгийн тайланд залруулах	Эрхлэгч, нягтлан бодогч	Я.Оюунчимэг Д.Оюунгэрэл
2	Гал тогооны дагалдах хэрэгслийн үнэ 1520.0 мянган төгрөгийг Тулга техник ХХК-д 2020 оны 12 сарын 30 -нд шилжүүлж авлага үүссэн. Уг авлагыг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй	1520,0	Зөвлөмж өгөх	Эрхлэгч, нягтлан бодогч	Я.Оюунчимэг Д.Оюунгэрэл
3	Тусгай зориулалттай бараа материал дансанд 3740,0 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийн шинж чанар бүхий хөрөнгийг бүртгэсэн байна.	3740,0	Санхүүгийн тайланд залруулах	Эрхлэгч, нягтлан бодогч	Я.Оюунчимэг Д.Оюунгэрэл
4	Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг шалгахад 27 төрлийн 151 мэдээлэл байршуулахаас батлагдсан төсөв, гүйцэтгэл, хэтрэлт хэмнэлтийн шалтгаан /тайлбарын хамт /, тухайн жилийн төсөвт орсон нэмэлт, өөрчлөлт, цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээ, санхүүгийн тайлан, хөрөнгийн болон урсгал зардалд тусгагдсан арга хэмжээний тендерийн ерөнхий мэдээлэл, таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа зэрэг нийт 23 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан байна.		Зөвлөмж өгөх	Эрхлэгч, нягтлан бодогч	Я.Оюунчимэг Д.Оюунгэрэл
<b>ДҮН</b>		<b>5454,3</b>			